


- 4.3.4. Цэцгээр чимэглэдэг сөөг сонгоход тансаг цэцэгтэй, цэцэглэлтийн хугацаа урттай, хурдан ургадаг, хялбар арчлагддаг модны төрөл зүйлийг сонгоно. Үүнд:
- 4.3.4.1. Хурц үнэргүй, эмх цэгцтэй модны төрлийг сонгож өргөсгүй, бага өргөстэй явган хүн болон тээврийн хэрэгсэлд саадгүй байхад анхаарах;
 - 4.3.4.2. Засаж тайрахад тэсвэртэй, сэргэн ургах чадвартай;
 - 4.3.4.3. Ургалт нь бат бэх, эсэргүүцэх чадвар сайтай, тоос шороо болон замын гадаргын цацрагийн дулааныг тэсвэрлэх чадвартай;
 - 4.3.4.4. Навчлах, цэцэглэх хугацаа нь эрт, жимс нь гоёл чимэглэлийн чанартай байх;
 - 4.3.4.5. Таримал хашлаганд сөөгийн төрлийг сонгох;
 - 4.3.4.6. Таримал хашлаганд модны төрлийг сонгохдоо эрт нахиалдаг, олон салаалсан, сэргэн ургах чадвартай, тайрахад тэсвэртэй, сүүдэрт тэсвэртэй, хортон шавж, өвчин багатай модны төрлийг сонгоно;
 - 4.3.4.7. Навчны хэмжээ жижиг ба өтгөн байх;
 - 4.3.4.8. Цэцгийн хэмжээ жижиг ба олон байх;
 - 4.3.4.9. Жимсний хэмжээ жижиг ба их байх;
 - 4.3.4.10. Шилжүүлэн суулгахад хялбар бөгөөд өндрийн хэмжээ тохиромжтой байх;
 - 4.3.4.11. Бутлалт сайтай ургадаг байх.
- 4.3.5 Хөрс бүрхэх ургамлыг дараах зүйлийг харгалзан сонгоно. Үүнд :
- ургамал нь намхан, бүрхэвч ихтэй, тархаж ургасан болон өтгөн иш, навчлаг шинж чанартай байна;
 - өсөлт ургалт хурдан, хүчтэй нөхөн үржих чадвартай, богино хугацаанд газар бүрхэж, урт хугацаанд (5-10 жил) үр дүн үзүүлнэ;
 - арчилгаа бага, хортон шавжийн нөлөө багатай, хогийн ургамлыг хүчтэй эсэргүүцэх, гишгэлэхэд тэсвэртэй, жилийн турш тодорхой гоёл чимэглэлийн үр нөлөөгөө хадгалж чадахуйц байх;
 - өнгө үзэмжтэй, навч, цэцэг, жимс нь сонирхол татахаас гадна хоргүй, үнэргүй, өргөсгүй байх.
- 4.3.6 Зүлгэн ургамлыг сонгохдоо дараах зүйлийг харгалзан сонгоно.
- сайн ширэг үүсгэдэг, буталж ургадаг, ургалт нь намхан, газрыг нягт бүрхдэг, үзэмжтэй байх;
 - навч нь нарийн зөөлөн, уян хатан, ургалтын хугацаа урттай байх;
 - дасан зохицох чадвартай, ган гачиг, өвчинд тэсвэртэй, хайчилж тайрах бодомжтой байх;
 - нөхөн үржих чадвар сайтай, бат бэх, соёолох чадвар сайн, сэргэн ургах чадамж өндөр байх;
 - зүлгийн үр нь өргөсгүй, үнэргүй, хүн, амьтанд сөрөг нөлөөгүй байх.

4.4 Модлог ургамлыг ногоон байгууламжийн элементүүдэд сонгох

- 4.4.1. Цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаас хамааран ганц нэгээр суулгасан мод, бүлэг мод сөөг, туж мод, таримал хашаа, эмжээр гэсэн элементүүд өргөн хэрэглэгддэг. Үүнд:
- ганц нэгээр суулгасан мод, сөөг: энэ нь зүлгэн дунд мод болон сөөгийг бусдаас онцгойлон ганц нэгээр тарьж суулгасныг хэлнэ;
 - бүлэг мод сөөг: зүлэг бүхий талбайд мод сөөгийг 2 ба түүнээс дээш хэд хэдээр суулгасан хэлбэр;
 - эгнүүлэн суулгасан мод сөөг: замын хажуугаар барилга байгууламжийн хоёр талаар гудамжинд нэг эгнээгээр суулгасан мод;
 - туж мод: их хэмжээний талбайд олон зуун мод суулгасан байхын хэлнэ. энэ нь томоохон паркийн байгууламжид хэрэглэгдэх бөгөөд нэг юм уу хэд хэдэн төрлийн мод сөөгийг суулгаж болно;
 - таримал хашлага: цэцэрлэгт талбайг хүний хөл хөдөлгөөнөөс хамгаалан тусгаарласан буюу паркийн доторх аль нэг хэсгийг нөгөө хэсгээс заагласан хашлага;
 - эмжээр: замын хашлаганы гадна тал, зүлэг, цэцгийн мандлын 0.5м-ээс өндөргүй сөөг сөөгөнцөр тарих.
- 4.4.2. Таримал хашлага нь цэцэрлэгт талбайг хүний хөл хөдөлгөөнөөс хамгаалан тусгаарлах, цэцэрлэгт хүрээлэнгийн доторх хэсгүүдийг зааглах үүрэгтэй. Таримал хашлагыг нэг эгнээнд төлөвлөхдөө нэг төрөл, зүйлийг эсхүл олон төрөл, зүйлийг хольж тарьж болно.
- 4.4.3. Танаж хэлбэржүүлэхгүй таримал хашлаганд намхан ургадаг сөөгүүд болох нохойн хошуу, бүйлс, гүйлс, чаргай, тавилгана зэргийг ашиглах нь тохиромжтой бөгөөд танаж хэлбэржүүлэх бол өрөл, хайлаас, шар хуайс, шивүүрт харгана, гялгар чаргай зэргийг ашиглаж болно.
- 4.4.4. Таримал хашлагыг өндөр 2-3м, дунд зэрэг 1-2м, намхан 0.5-1м гэж гурав ангилна. Эдгээр ангиллыг тухайн цэцэрлэгжүүлэх газрын онцлогт тохируулан төлөвлөнө.



Зураг 103. Таримал хашлаганы хэлбэрийг ишний доод хэсэгт нарны гэрэл хүрэлцэх хэмжээ (Жишээ зураг)

(Гэрлийн хүрэлцэх хэмжээнээс харгалзан хэлбэрийг үүсгэнэ. Ишний доод хэсэгт нарны гэрэл хүрэлцэхгүй бол иш хэсгийн мөчир, найлзуурууд үхдэг)

Хүснэгт 6. Модлог ургамлын ногоон байгууламжийн элементүүдэд сонгох

Ургамлын нэр	Ногоон байгууламжийн үндсэн элементүүд					
	1	2	3	4	5	6
Сибирь гацуур	*	*	*			
Сибирь шинэс	*	*	*	*		
Эгэл нарс	*	*	*	*		
Дагуур арц	*	*				*
Хуурамч хасаг арц	*	*				
Хонин арц	*	*				*
Сибирь арц	*	*				
Япон хайлаас	*	*	*	*	**	
Том үрт хайлаас	*	*	*	*	**	
Одойн хайлаас	*	*	*	*	**	*
Цагаан улиас	*	*	*	*		
Евро америк улиас	*	*	*	*		
Тоорой	*	*	*	*		
Лавар навчит улиас	*	*	*	*		
Үслэг улиас	*	*	*			
Ямаан бургас		*		*		
Хуурамч таван дохиурт бургас		*	*	*		
Шүүдэрт бургас		*	*	*		
Гурван дохиурт бургас		*		*		
Саваан бургас		*		*		
Цагаан бургас	*	*	*			
Сөөгөн хус		*		*		*
Жижиг навчит хус	*	*	*			
Хавтага навчит хус	*	*	*			
Төгрөг навчит хус	*	*	*			
Шөвгөр навчит агч	*	*	*			
Яшил навчит агч	*	*	*			
Талын агч	*	*	*			
Амарын тошлог		*			*	
Элдэв шилбэт тошлог		*			*	*
Мориссоны тошлог		*			*	*
Сибирь тошлог		*			*	*
Эгэл тошлог		*			*	*
Олон цэцэгт сухай	*	*	*			
Дагуур балгана		*			*	
Урт навчит балгана		*			*	*

Дагуур тэрэлж		*			*	
Ледебурын тэрэлж		*			*	*
Тэхийн шээг		*		*	*	**
Гималайн голтбор	*	*	*	*		
Мажаар голтбор	*	*	*	*	*	
Комаровын голтбор	*	*	*		*	
Бөхгөр голтбор	*	*	*		*	
Звягинцевийн голтбор	*	*	*		*	
Сөөглөг харгана		*				*
Сөөгөн харгана	*	*	*	*	**	
Удлиг харгана	*	*			**	
Летийн харгана	*	*	*	*		
Үхэр харгана	*	*			*	*
Одой харгана	*	*			*	*
Өргөст харгана	*	*	*	*	**	
Нарийн навчит харгана		*				*
Уссуур харгана		*			*	*
Улаан модот яшил		*			*	
Максимовичийн яшил		*			*	*
Мөнгөлөг жигд	*	*				
Муркрофтын жигд	*	*	*	*		
Цагаан яргай	*	*	*			
Улаан яргай	*	*	*			
Монгол догор		*				*
Sambucus williamsii	*	*	*			
Sambucus racemosa	*	*	*			
Сибирь гандигар	*	*	*			
Манж гандигар	*	*	*			
Алтайн даланхальс		*			*	*
Алтлаг даланхальс	*	*			*	
Арзгар даланхальс		*				*
Королковын даланхальс	*	*	*			
Макийн даланхальс	*	*	*			
Бяцхан навчит даланхальс		*			*	*
Рупрехтын даланхальс	*	*	*			
Татар далан хальс	*	*			*	*
Эгэл далан хальс	*	*			*	*

Тайлбар: *-Тухайн ногоон байгууламжийн элементэд ашиглагдах боломжтой, **-хэлбэржүүлэн ашиглах боломжтойг илтгэнэ (1-Ганц нэгээр суулгасан мод, 2-Бүлэг мод, сөөг, 3- Эгнүүлэн суулгасан мод, сөөг, 4-Зурвас, 5- Таримал хашлага, 6- Эмжээр)

4.5. Модлог ургамлыг тарих

- 4.5.1. Чимэглэлийн модлог ургамлыг тарьж ургуулахын өмнө стандартын шаардлага (Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага. MNS 6141:2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага. MNS 6139: 2010) хангасан суулгацыг мод үржүүлэг болон ойгоос тавих шаардлагын дагуу авна.
- 4.5.2. Суулгацыг шилжүүлэн суулгах, нүхийг бэлдэхдээ MNS 6773: 2019 стандартыг дагаж мөрдөнө.
- 4.5.3. Модонд нарны гэрэл, усны хангамж, хөрсний бүтэц нэн чухал бөгөөд бүс нутгийн онцлогоос шалтгаалан газрын хөрс янз бүр байна. Суулгах нүхийг ухагдаа үржил шимтэй хөрсийг ялгах, хөрсийг дахин ашиглах бэлтгэл ажлыг хангана. Мөн суулгацад хэрэглэгдэх дахин ашиглах үржил шимт хөрсийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна.
- 4.5.4. Хот, суурин газрын цэцэрлэгжүүлэлтэд зориулагдсан суулгацыг хавар 4-р сарын 15-аас 5-р сарын 25-ны хооронд, намар 10-р сарын 1-ээс 11-р сарын 1 хүртэл суулгана.
- 4.5.5. Навчит, шилмүүст мод, сөөг тарих хөрсийг шаардлагын дагуу бэлтгэнэ.
- 4.5.6. Мод, сөөгийн суулгацыг нүхний голд байрлуулан үндэсний хүзүүг газрын түвшнээс 10 см-ээс ихгүй гүнд суулгаж, нүхэнд хар шороог бага багаар хийж, дүүргэн нягтруулсны дараа ханатал усалсан байна.
- 4.5.7. Мод, сөөгийн суулгацыг тээвэрлэхдээ үндсийг нь зохих материалаар хучиж тээвэрлэнэ. Суулгацыг суулгах хүртэл хугацаанд тогтмол чийгтэй байлгана. Сөөгийн суулгацыг сонгон ухаж авах, тээвэрлэхдээ MNS 6255: 2011 стандартыг дагаж мөрдөнө.
- 4.5.8. Суулгацыг суулгасны дараа эхний сард 3-5 хоногт 1 удаа, дараагийн саруудад 5-7 хоногт 1 удаа 60-80 литр усаар усална. 2 дахь жилээс эхлэн 5-7 саруудад 7 хоногт 1 удаа, дараагийн саруудад 10 хоногт 1 удаа хөрсний чийгийг багтаамж 50%-аас доошгүй байхаар усална. Мөн Улаанбаатар хотын ногоон байгууламжийн арчлалт, усалгааны менежмент UCS 0804A:2020 баримт бичгийн ногоон байгууламжид тарьсан мод, таримлын усалгааны нормыг баримтална.
- 4.5.9. Ургалтын хугацааны арчилгааны шаардлагыг “Мод, сөөгийг суулгац арчлах” MNS6258-2:2011, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн арчлалт, усалгааны менежмент UCS0804A:2020 баримт бичгийн мод болон сөөг ургамлын арчилгааны технологийн зааврын дагуу арчилна.
- 4.5.10. Том модыг шилжүүлэн суулгах, арчлах ажлыг зохион байгуулахдаа “Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага” MNS 6774: 2019 стандартыг дагаж мөрдөнө.
- 4.5.11. Цэцэрлэгжүүлэлтийн зориулалттай стандартын 1-р зэргийн суулгацыг мод үржүүлгийн газар болон ойгоос мод шилжүүлэн суулгах журмын дагуу том модыг үндэстэй хамт ухаж авна. Шилмүүст, навчит мод болон сөөгийн 1-р зэргийн суулгацыг доорх хүснэгтээр (хүснэгт 7-9) харуулав.

Хүснэгт 7. Шилмүүст модны суулгацын 1-р зэрэг

№	Үзүүлэлт	1-р зэрэг	
1	Гадаад байдал	Гадна талын байдал өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа задраагүй, шилмүүс хатаагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр эгц, шулуун, бат бэх, үндэс их, өсөлт сайтай сайтай байна.	
2	Хэлбэр	Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд ишний нийт уртын 3/4-ыг эзэлсэн байна.	
3	Хэмжээ	Үндсэн мөчрийн тоо	10-15
		Титмийн тэлэлтийн голч, м	1.2-1.5
		Суулгацын өндөр, м	4.0 -өөс доошгүй
4	Үндэс	Өсөлт хөгжил сайтай, 3-аас доогүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна.	
		Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч, м	1.0-1.2
		Үндэстэй нь хамт шороотой хэсгийн зузаан, м	0.60-0.70

Тайлбар: Шилмүүст төрлийн модны суулгац. Ерөнхий шаардлага.
MNS 6139:2010, 1-р хүснэгт.

Хүснэгт 8. Навчит модны 1-р зэрэг


№	Үзүүлэлт	1-р зэрэг	
1	Гадаад байдал	Гадна талын байдал өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин, хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа задраагүй, уян зөөлөн саглагар мөчиртэй, иш нь бүдүүвтэр эгц, шулуун, бат бэх, үндэс их, өсөлт сайтай сайтай байна.	
2	Хэлбэр	Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд ишний нийт уртын 2/3-ыг эзэлсэн байна.	
3	Хэмжээ	Үндсэн мөчрийн тоо	10-13
		Титмийн тэлэлтийн голч, м	1.6-2.0
		Суулгацын өндөр, м	
		Хус	0.7 ба дээш
		Улиас	1.5 ба дээш
		Улиангар	1.5 ба дээш
		Тоорой	0.8 ба дээш
		Жигд	0.8 ба дээш
		Ледебурын бургас	1.2 ба дээш
		Агч	1.0 ба дээш
Хайлаас	0.8 ба дээш		
4	Үндэс	Өсөлт хөгжил сайтай, 3-аас доогүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна.	
		Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч, м	1.2-1.5
		Үндэстэй нь хамт шороотой хэсгийн зузаан, м	0.50-0.55

Тайлбар: Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага. MNS 6141:2010, 1-р хүснэгт.

Хүснэгт 9. Сөөгийн суулгацын 1-р зэрэг

№	Үзүүлэлт		I-р зэрэг
1	Гадаад байдал		Гадна талын өнгө байдал хэвийн, шалбарч гэмтээгүй, өвчин, хортонд нэрвэгдээгүй, нахиа нь хугацаанаасаа өмнө эрт задраагүй, мөчир, үндэс ихтэй, гувар нь эгц, шулуун, бат бэх, хугараагүй, өсөлт хөгжилт сайтай байна.
2	Хэлбэр		Титэм зөв хэлбэртэй байна.
3	Хэмжээ	Сөөгийн өндөр, м	1.2-1.5
		Үндсэн мөчрийн тоо	9-10
4	Үндэс	Үндэстэй нь хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн голч, см	Салаалсан үндэс ихтэй бөгөөд өсөлт, хөгжилт сайтай байхын дээр, үржил шимтэй шорооны хамт байна. 35-40 см байна.
		Үндэстэй нь хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн зузаан, см	Салаалсан үндэс ихтэй бөгөөд өсөлт, хөгжилт сайтай байхын дээр, үржил шимтэй шорооны хамт байна. 25-30 см байна.

Тайлбар: Сөөгийн суулгац, Ерөнхий шаардлага. MNS 6255:2011, 1-р хүснэгт.




Зураг 104. Том суулгацыг гар аргаар ухаж авах дараалал жишээ

4.5.12. Том модны суулгацын нүхийг MNS6139:2010, MNS 6141:2010 зэрэг стандартын дагуу ухаж бэлтгэнэ.



Зураг 105. Том суулгацыг техник ашиглан ухаж авах (Жишээ зураг)

4.5.13. Том модыг шилжүүлэн суулгахын өмнө нүхний ёроолд урьдчилан бэлтгэсэн үржил шимтэй хөрсийг (хар шороо: элс: бууц болон холимог бордоог 3:2:1 харьцаатай хольж багсарсан байна) 20-25см зузаан овоолж хийсэн байна.




Зураг 106. Том суулгацын өндрөөс хамаарсан нүхний хэмжээ (Жишээ зураг)

4.5.14. Суулгасан модыг салхинаас хамгаалж модны 2 буюу 3 талд гадас хатгаж, модны ишийг титмийн доогуур зөөлөн материалаар ороож, гадаснаас бэхлэн уяна.




Зураг 107. Шилжүүлэн суулгах модыг бэхлэх арга (Жишээ зураг)





Хүснэгт 8. Ногоон байгууламжид модлог ургамлын суулгацыг тариалах дараалал.



Тарих суулгацаа шууд тарих боломжгүй тохиолдолд шуудуу ухаж, суулгацыг хооронд нь ойрхон суулгаж, үндсийг нь хөрсөөр /элс/ хучиж болно. Энэ нь богино хугацааны хадгалалтын шийдэл юм.



Ногоон байгууламжид суулгацыг сонгон авахдаа MNS 6141: 2010, MNS 6139: 2010 стандартын дагуу сонгон тарина. Суулгацыг тарихдаа нүхний голд үндсийг нугалахгүйгээр жигд тарааж суулгана.

<p style="text-align: center;">3</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 110. (Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;">4</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 111. (Жишээ зураг)</i></p>
<p>Суулгацын хэмжээнд тохируулан нүхний диаметрийг тохируулна.</p>	<p>Суулгасны дараагаар хөрсийг сайтар нягтруулж гишгэж өгөх, нэг модыг 60-80 л усаар усална. Арчилгааг MNS 6258-2: 2011 стандартын дагуу хийнэ.</p>
<p style="text-align: center;">5</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 112. (Жишээ зураг)</i></p>	<p style="text-align: center;">6</p>  <p style="text-align: center;"><i>Зураг 113. (Жишээ зураг)</i></p>
<p>Суулгацыг зөв гүнд, үндэс системийг хөрсөнд тархан ургах бололцоог хангасан байх.</p>	<p>Суулгацыг суулгаснаас эхний 3 жилд арчилгааг усалгааг тогтмол хийж тухайн ургамлыг дасан зохицох, ургах нөхцөлийг бүрдүүлэх нь хамгийн чухал.</p>

5. ЗҮЛГИЙН УРГАМАЛ

Манай нийслэл хотын эрс тэс хуурай сэрүүн уур амьсгалын нөхцөлд зохицсон гадаад орнуудын болоод өөрийн орны байгалийн ургамлыг төрөл бүрийн зориулалтаар цэцэрлэгжүүлэлтэд тарьж ургуулж байна.

5.1. Зүлгийн ангилал, төрөл зүйл



Олон наст ургамлын илүү ихээр тарьж ургуулснаар агаарыг цэвэршүүлж, эрүүл ахуйн орчин бүрдүүлэхээс гадна хотыг чимэглэж өгдөг.








5.1.1. Хотын ногоон байгууламжид тарих зүлгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- ердийн зүлэг (хотын ногоон байгууламж, цэцэрлэгт талбай, айл, албан газар, цэцэрлэгт хүрээлэн);
- спортын чиглэлийн зүлэг (гольфийн талбай, хөл бөмбөг, спорт ордон, ширгийн хоккей);
- зам харилцааны зүлэг (авто машин, онгоцны буудал, явган хүний зам);
- хөрс хучигч зүлэг (нүцгэн газрыг ногооруулахад);
- хөрс хамгаалах зүлэг (усанд урсах, салхинд хийсэхээс хамгаална);
- холимог зүлэг (олон зүйлийн үндэсний системтэй ургамал) гэж ангилна.

5.1.2. Хот суурины ногоон байгууламжид тарих боломжтой нь зүлгийн ургамлыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 9. Зүлэгжүүлэлтэд ашиглах боломжтой ургамал

Зураг	Монгол, Латин нэр	Өндөр, см	Ургах орчин
 <i>Зураг 114.(Жишээ зураг)</i>	Нугын дурваалиг Phleum pratense	60-100	Хуурай нуга, сийрэгжсэн ой, хааяа замын дагуу ургана.
 <i>Зураг 115.(Жишээ зураг)</i>	Нугын үнэгэн сүүл Alopecurus pratensis	100-120	Сийрэг дэгнүүлт үетэн, талхлагдах, хадсаны дараа сэргэн ургахдаа сайн. Сүүдэрлэг газар ургана. Ойн ба эргийн нуга, шинэсэн ойд ургах боловч говийн уулсаар сүүдэрлэг газар ургана.
 <i>Зураг 116.(Жишээ зураг)</i>	Нарийн улаан толгой Agrostis capillaris	10-60	Богино мөлхөө иштэй, олон наст үет ургамал. Хүйтэнд тэсвэртэй, сайн чанарын зүлэг үүсгэдэг өвслөг ургамал юм. Хуурай хөндий, хаялгын нуга, сийрэгжсэн ой, ойн зах, гол нуурын эрэг, эргийн элсэнд ургана.
 <i>Зураг 117.(Жишээ зураг)</i>	Монгол улаан толгой Agrostis mongolica	40-60	10-25 см саглагар унь залаатай нэлээд урт, нарийн цэцэглэж үрлэх үедээ анхдагч мөчрөөсөө салж дэрвийнэ. Ойт хээр, хээрийн бүсэд эргийн хужирлаг, марцтай нугад ургана.
 <i>Зураг 118.(Жишээ зураг)</i>	Найлзуурт улаан толгой Agrostis stolonifera	10-20	Ус, намаг, гол нуурын эрэг, нугад ургана.
 <i>Зураг 119.(Жишээ зураг)</i>	Цагаан улаан толгой Agrostis alba	30-40	Газрын гадаргуугаар налж бүрхэнэ. Чийгтэй нөхцөлд бат бөх ширэг үүсгэнэ. Хуурай нуга, голын эрэг, нуур ба булаг шандын орчин, шалбаагтай газар ургана.
 <i>Зураг 120.(Жишээ зураг)</i>	Дэгнүүлт залаат өвс Deschampsia caespitosa	20-70	Нэлээд ширүүвтэр мөчиртэй, залаа баг цэцэгтэй, цэцэглэх үедээ дэрвийж сагсайж цац хэлбэртэй болно. Намаг, эргийн хайрга, чийглэг намгийн нугад ургана.

 <p>Зураг 121.(Жишээ зураг)</p>	<p>Тагийн биелэг Poa alpina</p>	<p>50</p>	<p>Өндөр уулын бүслүүрийн нуур, голын эрэг, нугад ургана.</p>
 <p>Зураг 122.(Жишээ зураг)</p>	<p>Хавтгай биелэг, Poa compressa</p>	<p>15-50</p>	<p>Гол горхины эрэг, ойн зах, хад асга, байц хадны ёроолд ургана.</p>
 <p>Зураг 123.(Жишээ зураг)</p>	<p>Тужийн биелэг, Poa nemoralis</p>	<p>30-100</p>	<p>Гол горхины эрэг, ойн зах, хад асга, байц хадны ёроолд ургана.</p>
 <p>Зураг 124.(Жишээ зураг)</p>	<p>Нугын биелэг, Poa pratensis</p>	<p>30-90</p>	<p>Ойн татмын нуга, хээрийн нуга, нугархаг энгэр, шинэсэн ой түүний зах, хусан төгөл, эргийн элс хайрганд ургана.</p>
 <p>Зураг 125.(Жишээ зураг)</p>	<p>Улаан ботууль, Festuca rubra</p>	<p>20-75</p>	<p>Өндөр уулын ба ойн бүслүүрт тагийн нуга, тогтоол ус, байц хадны ёроол, хаг хөвдөн таг, чулуурхаг хажуу, хад асгад ургана.</p>
 <p>Зураг 126.(Жишээ зураг)</p>	<p>Валиссын ботууль Festuca valesiaca</p>	<p>40-50</p>	<p>Чимэглэлийн ач холбогдолтой, ган болон хүйтэнд тэсвэртэй, тархац ихтэй ердийн зүлгийн ургамал юм. Уулын хээр тэгш тал, чулуутай ба хайргатай хажуу байц хад, эргийн хайрганд ургана.</p>
 <p>Зураг 127.(Жишээ зураг)</p>	<p>Соргүй согоовор Bromus inermis</p>	<p>30-100</p>	<p>Хүчирхэг дэгнүүл, ширэг үүсгэдэг. Давтагдаж талхлахад тэсвэртэй. Хөнгөн шавранцар, элсэрхэг хар шороон хөрсөнд илүү сайн ургана. Харин хүнд шавранцар, давстай орчинд муу ургана.</p>

 <p>Зураг 128.(Жишээ зураг)</p>	<p>Саман ерхөг Agroperon cristatum</p>	<p>25-30</p>	<p>20-60 см ийн гүн үндэстэй. Давтагдах, талхлалтад тэсвэртэй Тэгш тал, хуурай нуга, элс чулуурхаг хажуу, эргийн хайрга, заримдаа байц хадны завсар ургана.</p>
 <p>Зураг 129.(Жишээ зураг)</p>	<p>Мөлхөө хиаг Agroperon repens</p>	<p>12</p>	<p>Элэгдсэн хаягдал газрыг зүлэгжүүлэхэд хэрэглэгдэх сайн чанарын зүлгийн ургамал. Нуга, хажуу, эргийн хайрга, элс, сийрэг ой, сөөгөн ширэнгэ, тариа ногооны талбай, цэцэрлэгийн орчин тойрон замын дагуу ургана.</p>
 <p>Зураг 130.(Жишээ зураг)</p>	<p>Сибирь өлөн Elymus sibiricus</p>	<p>140</p>	<p>Өсөлт сайн явагддаг боловч хөрсийг бүрхэх талаар тааруу, элэгдсэн газрын хөрсийг хамгаалахад тариалж болно. Хаялгын нуга, хээржсүү нугархаг энгэр, ойн зах, сөөгөн ширэнгэ, эргийн элс хайрганд ургана.</p>
 <p>Зураг 131.(Жишээ зураг)</p>	<p>Ширэг улалж Carex durius-cula</p>	<p>5-15</p>	<p>Хүчирхэг үндэстэй намхан ургамал. Ширэг нягт үүсгэнэ. Талхлагдахад тэсвэртэй. Хүйтэн болон ганд тэсвэртэй. Элсэрхэг тэгш тал, уулын хээр, гол горхины чийглэг хужирлаг нуга, чулуурхаг хажууд ургана.</p>
 <p>Зураг 132.(Жишээ зураг)</p>	<p>Зогдор улалж Carex pedi-formis</p>	<p>30-40</p>	<p>Ташиж дээшээ гарсан богиноссон үндэслэг иш нь нягт өтгөн дэгнүүлийг үүсгэдэг. Голын эрэг дагасан хайрган хөрстэй газраар ургана.</p>

5.2. Зүлгийн ургамлыг ногоон байгууламжид сонгох

- 5.2.1. Хотын ногоон байгууламжийн мод, сөөг, цэцэгт байгууламжтай, усан сан, оргилуур бүхий том цэцэрлэгийн сул задгай талбайг зүлэгжүүлэхэд согоовор, ботууль, биелэг өвс тохиромжтой.
- 5.2.2. Мод, сөөг, цэцгийн мандал, тоглоомын талбай, явган зам бүхий цэцэрлэгт гудамж, орон сууцны барилгын хооронд ерхөг, согоовор сонгоно.
- 5.2.3. Албан байгууллагын орчим, хотын төв хэсэгт ботууль болон гоё үзэмжтэй ургамлыг тасралтгүй цэцэглэж байхаар тооцоолж тарина.
- 5.2.4. Хажуу, налуу газарт хөрс хучигч галуун гичгэнэ. Хотын доторх эрэг жалга, судгийн эргээр хиаг сонгох нь тохиромжтой.
- 5.2.5. Биеийн тамирын талбай, цэнгэлдэх хүрээлэнд галуун гичгэнэ таривал зохино. Зүлэгжүүлэх талбайд олон наст ургамлын үрийг дангаар буюу хольж тарина.

- 5.2.6. Зүлгийг дангаар болон цэцгийн ургамалтай хольж тарьж болно.
- 5.2.7. Их хэмжээний талбайд зүлэг болон цэцгийн ургамлыг хольж тарихыг мавританы зүлэг гэж нэрлэдэг ба дараах онцлогтой байдаг. Үүнд:
- мавританы зүлгэнд ашиглагдаж байгаа цэцгийн өндөр нь 5-10 см-ээс хэтрэхгүй;
 - мавританы зүлгэнд ашиглагдах цэцгийн нэг төрлийн эсхүл олон төрлийн цэцгийг сонгох боломжтой.



Зураг 133. Мавританы зүлэг (Жишээ зураг)

5.3 Зүлгийг тарьж ургуулах

Зүлгийг хот суурины ногоон байгууламжид тарихдаа үрээр шууд тарих болон хуйлдаг зүлэг гэсэн 2 хэлбэртэй. Үүнээс хуйлдаг зүлэг нь зүлгийн зориулалтын талбайд бэлтгэх бөгөөд хөрсний боловсруулалт хийгдсэн талбайд зөөвөрлөн тарьж ургуулна.



- 5.3.1. Хот, суурин газрын нийтийн эзэмшил, хязгаарлагдмал хэрэгцээний болон тусгай зориулалтын ногоон байгууламжийн талбайг зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлахад MNS 6260: 2020 стандартыг баримтална. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн арчлалт, усалгааны менежмент UCS 0804A: 2020 баримт бичгийн зааврын дагуу гүйцэтгэнэ.
- 5.3.2. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжид тарих зүлгийн үрийг чанарын үзүүлэлтээс (хүснэгт 6.2) хамааран сонгоно.
- 5.3.3. Хөрсийг 18-20см гүн хагалж, хайрга чулууг цэвэрлэж, үлдсэн шороог буталж, нунтаглана.
- 5.3.4. Шигшсэн элс, хар шороог 1:2 хэмжээтэй хольж өнгөн хөрсийг бэлтгэнэ. Зүлэгжүүлэх талбайд хөрсийг 20 см зузаан дэвсэж, булдаж, нягтруулан сайтар тэгшилнэ.
- 5.3.5. Талбайг бэлтгэсний дараа 20 см гүнд нэвчтэл усална.
- 5.3.6. Хот тохижилтод 1м² талбайн зүлэгжүүлэх нормыг цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн зориулалтаас нь хамаарч Зүлэгжүүлэх талбай бэлтгэх үр тарих, арчлахад MNS 6260: 2020 дагаж мөрдөнө.

Хүснэгт 10. Зүлгийн үрийн 1-р зэрэг

№	Ургамлын нэр	Бүх жинд үндсэн таримлын эзлэх, %	Бусад ургамлын үр, %	1кг үрэнд байх хог ургамлын үр, ш	Соёололтын доод хэмжээ, %
1	Нугын биелэг	95	0.5	500	75
2	Улаан ботууль	95	0.5	250	85
3	Саман ерхөг	90	0.8	500	80
4	Соргүй согоовор	95	0.6	500	80
5	Нугын ботууль	95	0.5	250	85
6	Дагуурын өлөнгө	90	1.5	500	80
7	Сибирийн өлөнгө	90	0.6	500	85
8	Улалж	95	0.5	500	85
9	Улаан толгой	95	0.5	500	80
10	Талын дурваалиг	95	0.5	500	85







Тайлбар: Зүлэгжүүлэх талбай бэлтгэх үр тарих, арчлахад MNS 6260: 2020, 1-р хүснэгт

Хүснэгт 11. Зүлгийн ургамлыг тарих

	<p>Хөрсийг 15-аас 20см гүн хагалж, хайрга чулууг цэвэрлэж, үлдсэн шороог буталж, зөөллөнө.</p>
	<p>Үрийг салхи багатай, тогтуун өдөр талбайд жигд цацаад, хөнгөн хөрсөнд 3см, дунд зэрэг хөрсөнд 2см, шавранцар хөрсөнд 1см зузаан хучна.</p>

Зураг 134. (Жишээ зураг)

Зураг 135. (Жишээ зураг)

	<p>1м2 талбайг зүлэгжүүлэх үрийн хэмжээг MNS 6260: 2020 стандартын дагуу тарина.</p>
	<p>Шүдний хооронд 7-оос 8см зайтай тармуурыг 2см хүртэл гүн ортол самнаж ховилд нь үрийг цувуулж хийгээд гадаргууг элсээр хучна.</p>
	<p>Тарьсан үрийг соёолтол нь хөрсний 5-аас 10 см-ийн гүнд тогтмол чийгтэй байлгана.</p>
	<p>Усалгааг өдөр бүр өглөө, оройн сэрүүнд 1 м2 талбайд 30-аас 40 литр усаар мананжуулан усална.</p>
	<p>Хог ургамлыг эхний жил үндэстэй нь зулгаан авч зайлуулна.</p>
	<p>Ногоон байгууламжид тарьсан зүлгийг 14 хоног тутамд 10см өндөртэй хяргаж тэгшлэхэд бутлалт сайтай өтгөн болж ургана.</p>

6. ЦЭЦГИЙН УРГАМАЛ






Зөвхөн нэг жилийн урин дулаан цагт ургаж амьдрах хэврэг зөөлөн найлзуур бүхий ургамлыг цэцгийн гэх бөгөөд тэдгээрийг амьдрах хугацаагаар нь ганц наст, хоёр наст, олон наст цэцгийн ургамал гэж ангилна. Доорх хүснэгтэд (хүснэгт 8.1, 8.2) хот суурин газрын ногоон байгууламжид тарьж ургуулах боломжтой нь тогтоогдсон цэцгийн ургамлуудыг харууллаа.








6.1. Ганц наст цэцгийн ургамал









Гоёл чимэглэлийн ургамлууд олон амин хэлбэртэй байдгийг дээр өгүүлсэн. Эдгээр нь ногоон байгууламжид янз бүрийн зориулалтаар чимэглэх боломжийг олгодог. Нэг жил болоод хагдрах ургамлыг нэг наст ургамал гэнэ.

6.1.1. Ганц наст цэцгийг хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн тухайн жилийн өнгө төрхийг тодорхойлох, загвар дизайнд тулгуурлан хэлбэр дүрсийг шийдвэрлэх гол элемент болгон ашиглахыг зэрэгцээ, хатуу хучилттай зам талбайд зураг төслийн дагуу зөөвөрлөн ашиглахад нэн тохиромжтой.

Хүснэгт 12. Ганц наст цэцгийн ургамал

Ганц наст цэцгийн		Өндөр, см	Үрсэлгээ хийх, цэцэглэх, үр боловсрох хугацаа	Ургах орчин
Зураг	Монгол, Латин нэр			
 Зураг 142. (Жишээ зураг)	Гүндсамбуу, Ageratum mexicanum	15-60	Цэнхэр өнгөтэй. 3-р сарын сүүлч 4-р сарын эхээр үрслүүлнэ. 7-р сарын эхээр цэцэглэж, 9-р сарын эхээр үр боловсорно.	Хүйтэнд тэсвэртэй. Наранд ээвэр, үржил шимтэй хөрсөнд ургана
 Зураг 143. (Жишээ зураг)	Арслангийн жавьж Antir- rhinum majus	30-70	Цагаан, шар, хөх ягаан зэрэг олон өнгөтэй. 3-р сард үрслүүлнэ. 10-р сар хүртэл 85-90 хоног цэцэглэн, үр нь боловсорно.	Хөрс голддоггүй, наранд ээвэр газар ургана.
 Зураг 144. (Жишээ зураг)	Башир Dian- thus barbatus	30-50	Шар, улаан, ягаан зэрэг өнгөтэй. 2-р сарын эхээр үрслүүлнэ. 6-р сарын сүүлчээс эхлэн намар орой болтол цэцэглэнэ.	Наранд ээвэр, үржил шимтэй хөрсөнд ургана.
 Зураг 145. (Жишээ зураг)	Нангиад башир Dian- thus chinensis	35-40	Цэцэг нь ягаан, улаан толботой. 6-р сард цэцэглэж, 9-р сарын эхээр үр боловсорно.	Гэрэлсэг, үржил шимтэй хөрсөнд ургана.
 Зураг 146. (Жишээ зураг)	Шабо башир Dianthus caryophyllus	30-45	Анхилуун үнэртэй, ягаан, цагаан, улаан зэрэг олон өнгөтэй. 2-р сарын эхээр үрслүүлнэ. 6-р сарын дунд үеэс 60-75 хоног цэцэглэнэ.	Наранд ээвэр газар, ялзмагтай хөрсөнд тарина.

 <p>(Жишээ зураг)</p>	<p>Гээгцэцэг Delphinium ajacis</p>	<p>50-100</p>	<p>Цэнхэр, цагаан, ягаан зэрэг өнгийн цэцэгтэй. Үрийг 3-р сарын дундуур үрслүүлнэ. 7-р сарын сүүлчээс 9-р сарын сүүлч хүртэл цэцэглэнэ.</p>	<p>Нартай, чийглэг, ялзмагтай хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 147.(Жишээ зураг)</p>	<p>Алаг сэдэргэнэ Convolvulus tricolor</p>	<p>30-50</p>	<p>Шар, цагаан өнгийн цэцэгтэй. 5-р ил талбайд шууд тарина.</p>	<p>Хөрс голдоггүй.</p>
 <p>Зураг 148.(Жишээ зураг)</p>	<p>Аранзалаа Phlox drum- mondii</p>	<p>15-75</p>	<p>Цагаан, хүрэн улаан өнгийн цэцэгтэй. 2-р сарын эхээр үрслүүлнэ. 6-р сарын сүүлчээс цэцэглэнэ.</p>	<p>Хүйтэнд тэсвэртэй, ямар ч хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 149.(Жишээ зураг)</p>	<p>Баавар цэцэг Scabiosa atro- purpurea</p>	<p>90</p>	<p>Цагаан, ягаан, улаан, шар, цэнхэр зэрэг олон өнгийн цэцэгтэй. 4-р сарын эхээр үрслүүлнэ. 25-30 хоног цэцэглэж, 8 -р сарын дундаас үр боловсорно.</p>	<p>Наранд ээвэр газар, ялзмагтай хөрсөнд тарина.</p>
 <p>Зураг 150.(Жишээ зураг)</p>	<p>Гагадай Amaranthus caudatus</p>	<p>100</p>	<p>Хар хүрэн, иш нь хүрэн улаан, залаа баг цэцэгтэй.</p>	<p>Нартай ээвэр газар, үржил шимтэй хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 151.(Жишээ зураг)</p>	<p>Цайгана Godetia amoena</p>	<p>30-50</p>	<p>Цэцэг нь энгийн хэлтэслэг. 3-р сарын дундуур үрслүүлнэ. 6-р сарын сүүлчээс эхлэн цэцэглэж, 8-р сараас үр боловсорно.</p>	<p>Гэрэлсэг дулаан, чийглэг хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 152.(Жишээ зураг)</p>	<p>Далиу хилэн цэцэг Tagetes patula</p>	<p>20-40</p>	<p>Шар, хүрэн өнгийн хосолсон өнгөтэй. Ил талбайд 5-р сарын сүүлчээр тарина. Үр тарьснаас хойш 60 хоногийн дараа цэцэглэж, 9-р сард үр боловсорно.</p>	<p>Наранд ээвэр газар, үржил шимтэй хөрсөнд тарина</p>
 <p>Зураг 153.(Жишээ зураг)</p>	<p>Алталж Dimorphotheca annus</p>	<p>30-40</p>	<p>Цэцэг нь цагаан, шаргал өнгөтэй. 9-р сарын дунд үе хүртэл үргэлжлэн цэцэглэнэ</p>	<p>Наранд ээвэр газар, үржил шим сайтай хөрсөнд ургана.</p>

 Зураг 154. (Жишээ зураг)	Мандарваа Dahlia pin-nata	100-200	Хүрэн улаан, ягаан, шар, улбар зэрэг олон өнгийн цэцэгтэй. 7-р сарын сүүлч, 8-р сарын эхээр цэцэглэж эхлэн намар орой болтол үргэлжилнэ.	Үржил шим сайтай, наранд ээвэр газар сайн ургана.
 Зураг 155. (Жишээ зураг)	Ловил Lobelia eri-nus	10-15	Хөх, ягаан, цагаан зэрэг олон өнгийн цэцэгтэй. 3 -р сарын эхээр үрслүүлнэ.	Наранд ээвэр, чийглэг хөрсөнд ургахдаа сайн.
 Зураг 156. (Жишээ зураг)	Нангиад гол гэсэр Callistephus chinensis	20-90	Цэцэг нь ягаан, улаан толботой. 3-р сарын сүүлч 4-р сарын эхээр үрслүүлнэ. 6-р сараас эхлэн цэцэглэж, 9-р сарын эхээр үр боловсорно.	Үржил шимтэй хөрсөнд ургуулна. Гэрэлсэг, хүйтэнд тэсвэртэй.
 Зураг 157. (Жишээ зураг)	Нарийн навчит Хилэнцэцэг Tagetes signata	15-20	Цэцэг нь 1-2 өнгө хосолсон. 5-р сарын дундуур үрийг ил талбайд тарина. 7-р сарын дундаас 8-р сарын сүүлч хүртэл цэцэглэж, 9-р дүгээр сард үр боловсорно.	Хөрс голдоггүй, наранд ээвэр газар ургадаг.
 Зураг 158. (Жишээ зураг)	Нил (Алагнүдэн) Viola tricolor	15-30	Цагаан, шар, хөх, ягаан зэрэг олон өнгөтэй. 3-р сарын эхээр үрслүүлнэ.	Хүйтэнд тэсвэртэй, ялзмаг бүхий хар шороон хөрсөнд сайн ургана.
 Зураг 159. (Жишээ зураг)	Өндөр Хилэнцэцэг Tagetes erecta	25-100	Шар, улбар шар өнгийн цэцэгтэй. Үрийг 4-р сарын эхээр үрслүүлнэ. 7-р сард цэцэглэнэ.	Наранд ээвэр, үржил шимтэй хөрсөнд тарина. Хөрс голдоггүй.
 Зураг 160. (Жишээ зураг)	Алталж Dimorphotheca aurantiaca	50	Цэцэг нь цагаан, шаргал өнгөтэй. 9-р сарын дунд үе хүртэл үргэлжлэн цэцэглэнэ.	Наранд ээвэр, үржил шимтэй хөрсөнд тарина.
 Зураг 161. (Жишээ зураг)	Дэмэг Alyssum maritimum	15	Анхилуун жижиг цагаан, ягаан өнгийн цэцэгтэй. Үрийн 4-р сарын сүүлчээр үрслүүлнэ. 6-р сараас намар орой болтол цэцэглэнэ. 9-р сарын дунд үеэс үр боловсорно.	Үржил шимтэй, чийглэг хөрсөнд тохиромжтой.





 <p>Зураг 162. (Жишээ зураг)</p>	<p>Мираан Coreopsis tinctoria</p>	<p>50</p>	<p>Шар, шаргал, хүрэн улаан өнгийн цэцэгтэй. Үрийг 3-р сарын сүүлчээр үрслүүлнэ. 6-р сарын дундаас 8-р сарын дунд үе хүртэл 60-65 хоног цэцэглэнэ.</p>	<p>Хөнгөн элсэнцэр хөрсөнд ургахдаа тохиромжтой.</p>
 <p>Зураг 163. (Жишээ зураг)</p>	<p>Цайгана Clarkia concinna</p>	<p>60</p>	<p>Цэцэг нь энгийн хэлтэслэг. 3-р сарын дундуур үрслүүлнэ. 6-р сарын сүүлчээс эхлэн цэцэглэж, 8-р сараас үр боловсорно.</p>	<p>Гэрэлсэг дулаан, чийглэг хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 164. (Жишээ зураг)</p>	<p>Хуурай цэцэгтэн, Helichrysum plicatum</p>	<p>25-100</p>	<p>Цагаан эсхүл ягаан, улаан, шаргал, шар өнгөтэй. Үрийг 4 сард үрслүүлнэ.</p>	<p>Үржил шимтэй сийрэг хөрсөнд ургана. Хүйтэнд, ганд тэсвэртэй. Усалгаа бага шаарддаг.</p>

6.2. Олон наст цэцгийн ургамал






Олон жилээр амьдрах зохилдлого бүхий өвслөг ургамлыг олон наст цэцэг гэж нэрлэнэ. Олон наст цэцгийн ургамлын найлзуур жил бүр шинээр үүсэж, хагдарч байх боловч түүний сэргэлтийн нахиа бүхий үндэс, үндэслэг иш, булцуу газрын хөрсөн доор өвөлжиж, дараа жил шинэ найлзуур төрүүлэх чадвартай.

- 6.2.1. Олон наст цэцгийн ургамлыг хотын ногоон байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болох цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, орон сууцны хороолол, тусгай зориулалтын ногоон байгууламж зэргүүдэд тарих боломжтой.

Хүснэгт 13. Олон наст цэцгийн ургамал

Олон наст цэцгийн		Өндөр, см	Олон наст цэцгийн		Ургах орчин
Зураг	Монгол, Латин нэр		Цэцэглэх хугацаа	Ургалтын хугацаа	
 Зураг 165. (Жишээ зураг)	Шар хумхаал Nemegocallis lilio-asphodelus	40-70	Цэцэг нь алтлаг шар, цайвар шар өнгө хосолсон. 7-р сарын дундуур цэцэглэнэ.	8-р сарын сүүлээр үрлэж дунджаар 110 хоног ургалт нь үргэлжилнэ. Үр үндэслэг ишээр үржих чадвар сайн.	Ойн зах, нуга, нугат хажуу, голын шугуй, татмын нугад элбэг тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал юм.
 Зураг 166. (Жишээ зураг)	Бага хумхаал Nemegocallis minor	20-50	Тод шар, хүрэн боровтор өнгө хосолсон цэцэгтэй. 7-р сарын дундуур цэцэглэнэ.	8-р сарын сүүлээр үрлэж дунджаар 110 хоног ургалт нь үргэлжилнэ. Үр үндэслэг ишээр үржих чадвар сайн.	Ойн зах, нуга, нугат хажуу, голын шугуй, татмын нугад элбэг тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал юм.
 Зураг 167. (Жишээ зураг)	Нарийн навчит сараана Lilium pumilium	18-80	Цэцэг нь тод улаан цацаг баг цэцэгтэй. 6-р сарын эхээр цухуйж 7-р сарын эхээр цэцэглэнэ.	7-р сарын сүүлээр үрлэж ойролцоогоор 70 хоног үргэлжилнэ. Сонгинолог булцуугаар үржинэ.	Наранд ээвэр, нугат хээр, чулуурхаг хажуу, хааяа элсэрхэг хөрстэй нарсан шугуйд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал
 Зураг 168. (Жишээ зураг)	Анхилуун мухар цагаан Polygonatum odoratum	30-50	Цэцэг нь цагаан өнгөтэй. 5-р сарын эхээр цухуйж, 6-р сарын эхээр цэцэглэнэ.	8-р сарын эхээр үрлэж ойролцоогоор 110 хоног ургалт нь үргэлжилнэ. Үндэслэг ишээр хялбархан үржинэ.	Шинэсэн ой, нарсан ой, хусан төгөл, сөөгөн ширэнгэд, хад чулууны харанхуй ангалд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэн болон ганд тэсвэртэй.

 <p>Зураг 169. (Жишээ зураг)</p>	<p>Бунгийн цахилдаг <i>Iris bungei</i></p>	<p>34-42</p>	<p>Ягавтар хөх өнгийн том цэцгүүдтэй. 4-р сарын 3-р 10 хоногоос цухуйж 6- сарын 7-оос 27 хооронд цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын дундуур үр боловсорч, дунджаар 110 хоног ургаад хагдардаг. Үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Хээрийн элсэрхэг, чулуурхаг, хайргархаг хажууд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 170. (Жишээ зураг)</p>	<p>Шар цахилдаг <i>Iris flavissima</i></p>	<p>15-20</p>	<p>5-р сарын эхээр сэргэн ургаж 6-р сарын 5-аас 20-ны хооронд цэцэглэнэ.</p>	<p>Ойролцоогоор 100 хоног ургалт нь үргэлжилнэ.</p>	<p>Чулуурхаг хайргатай, хээржүү уулын энгэр, хад асгатай сэргэн дагаж элсэрхэг хөрсөнд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 171. (Жишээ зураг)</p>	<p>Сибирь цахилдаг <i>Iris sibirica</i></p>	<p>15</p>	<p>5 сарын дундуур сэргэн ургаж 6 сарын 13-20-д цэцэглэнэ.</p>	<p>Дунджаар ургах хугацаа нь 110 орчим хоног үргэлжилнэ..</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй. Голын эрэг, намгархаг нуга, болдог намагт ургана.</p>
 <p>Зураг 172. (Жишээ зураг)</p>	<p>Бар цоохор цахилдаг <i>Iris tigrida</i></p>	<p>15-20</p>	<p>Цэцэг тод нил өнгөтэй. -р сарын 2-р 10 хоногоос сэргэн ургаж 5-р сарын сүүлээс 1 сар орчим цэцэглэнэ.</p>	<p>4 Дунджаар 110 орчим хоног ургаад хагдардаг. Үндэслэг ишээр үрждэг.</p>	<p>Хад, хайрга чулуутай хээрт хажуу, асга, элс хайргатай хээрт ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 173. (Жишээ зураг)</p>	<p>Өвслөг башир <i>Dianthus deltoideus</i></p>	<p>30-40</p>	<p>Цэцэг нь улаан ягаан, үзүүр хэсэг нь тод улаан толбуудтай байдаг. 6-р сарын 3-р 10 хоногоос цухуйж 7-р сарын сүүл 8-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын дундуур үрлэж ойролцоогоор 90-100 хоног ургалт үргэлжилнэ.</p>	<p>Нарийхан мөлхөө, үндэслэг иштэй, сийрэгдүү ширгэн бут үүсгэдэг. Ойн зах нугад ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p><i>Зураг 174. (Жишээ зураг)</i></p>	<p>Өдлөг башир <i>Dianthus plumag- ius</i></p>	<p>40-50</p>	<p>Цэцэг нь 3-5см голчтой, хэлтэслэг энгийн, улаан ягаан эсхүл цагаан, өнгө хосолсон, анхилуун үнэтэй. 6-р сарын 3 дах 10 хоногоос цухуйж, 7-р сарын сүүл, 8-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>9-р сарын эхээр үр нь боловсорч, 10-р сарын эхээр ногооноороо хөлдөнө. Үрээр, мөчир, бутгаар хувааж үржүүлнэ.</p>	<p>Бууц, үртсээр хучиж өвөлжүүлнэ. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэр муутай ургамал.</p>
 <p><i>Зураг 175. (Жишээ зураг)</i></p>	<p>Жавхаалаг башир <i>Dianthus super- bus</i></p>	<p>20-50</p>	<p>Цайвар ягаан өнгийн цэцэгтэй. 5-р сарын 3-р 10 хоногоос цухуйж 7-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үр боловсорч, дунджаар 110 хоног ургаад хагдарна.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэн, ганд тэсвэр муутай. Уулын ойн бүслүүрт нуга, ойн чөлөө, хар мод ба хушин ой, нугархаг энгэр, бэл, голын эрэг, сөөгөн ширэнгэд, таг цармын бүслүүрт нуга, гол горхины эрэгт ургана.</p>
 <p><i>Зураг 176. (Жишээ зураг)</i></p>	<p>Ягаан цээнэ <i>Raeonia apomala</i></p>	<p>60-100</p>	<p>Том хүрэн ягаан цэцэгтэй. 5-р сарын эхний 10 хоногт цухуйж 5-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын сүүлчээр үр нь боловсорч дунджаар 120 орчим хоног ургаад хагдардаг.</p>	<p>Шинэсэн ой, холимог ой, хусан төгөл, ойн захад элбэг тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй, ганд тэсвэр муутай.</p>
 <p><i>Зураг 177. (Жишээ зураг)</i></p>	<p>Цагаан цээнэ <i>Raeonia lactiflora</i></p>	<p>100-110</p>	<p>Цэцэг нь цагаан ишнийхээ үзүүрт ганцаар байрлана. 5-р сарын сүүлээр цухуйж , 6-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үрлэж ойролцоогоор 100 хоног ургалт үргэлжилнэ. Үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Халхын голын зүүн эрэгт нугархаг хажуу, элдэв өвст нуга, сөөгөн ширэнгэ, голын хөндийн уулын хормой даган ургана. Хүйтэнд тэсвэртэй, ганд тэсвэр муутай.</p>
 <p><i>Зураг 178. (Жишээ зураг)</i></p>	<p>Азийн Жамъяндаг <i>Trollius asiaticus</i></p>	<p>20-80</p>	<p>Цэцэг нь улбар шар өнгөтэй. 5-р сарын 2-р 10 хонгоос цухуйж 6-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын 2-р 10 хоногоос үрлэж ойролцоогоор 70 хоног ургалт үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, хусан төгөл, ширэнгэ, голын шугуй, түүнчлэн таг цармын нугад ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал.</p>

 <p>Зураг 179. (Жишээ зураг)</p>	<p>Нангиад Жамъянмядаг Trollius chinensis</p>	<p>100</p>	<p>Цэцэг нь улбар шаргал өнгөтэй. 5-р сарын 3-р 10 хоногт цухуйж, 7-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>Наймдугаар сарын эхээр үр нь боловсорч дунджаар 120 хоног ургаад хагдардаг. Үрээр үржинэ.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал. Элсэрхэг, чийглэг хөрсөнд ургана.</p>
 <p>Зураг 180. (Жишээ зураг)</p>	<p>Канад удвал Aquilegia canadensis</p>	<p>70</p>	<p>Цэцэг нь улаан шаргал өнгөтэй. 6-р сарын эхээр цухуйж, 7-р сард цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын эхээр үр нь боловсорч, дунджаар 90 хоног ургаад хагдардаг. Үрээр үржинэ.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэр муутай тул намар хучиж өвөлжүүлнэ.</p>
 <p>Зураг 181. (Жишээ зураг)</p>	<p>Олимпын удвал Aquilegia alpina</p>	<p>30-60</p>	<p>Цэцэг нь цайвар ягаан, цайвар хөх хосолсон өнгөтэй. 6-р сарын эхээр цухуйж, 7-р сарын эхний 10 хоногт цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын 3 дугаар 10 хоногоос үр боловсорч, дунджаар 70 хоног ургана. Үрээр үржинэ.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй ургамал.</p>
 <p>Зураг 182. (Жишээ зураг)</p>	<p>Хурц цоморлогт Удвал Aquilegia vulgaris</p>	<p>100</p>	<p>Цэцэг нь хар хүрэн өнгөтэй. 6-р сарын эхээр цухуйж, 7-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлчээр үр нь боловсорч, дунджаар 90 хоног ургаад хагдардаг.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэр муутай тул намар хучиж өвөлжүүлнэ.</p>
 <p>Зураг 183. (Жишээ зураг)</p>	<p>Сибирь Удвал Aquilegia sibirica</p>	<p>25-70</p>	<p>Цэцэг нь хөх цэнхэр өнгөтэй. 5-р сарын эхний 10 хоногт цухуйж 6-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын сүүлчээр үрлэж ургалт ойролцоогоо 100 хоног үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, сийрэг, холимог ой, тэдгээрийн чөлөө, хусан төгөл, таг цармын нуга, үхэр чулуутай нураг, гол горхи дагуу ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>





 <p>Зураг 184. (Жишээ зураг)</p>	<p>Том цэцэгт гэзэг цэцэг Delphinium gran- diflorum</p>	<p>30-45</p>	<p>Цэцэг нь цэнхэр өнгөтэй. 5-р сарын сүүлээр цухуйж 7-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үр боловсорч 90 хоног ургаад хагдарна. Үрээр үржинэ.</p>	<p>Нуга, алаг өвст тал, хээрт, голын хөндий, хуурай нуга, ойн цоорхойд ургана. Хүйтэнд тэсвэртэй, гантай жил байнга хортонд нэрвэгдэнэ.</p>
 <p>Зураг 185. (Жишээ зураг)</p>	<p>Шар хорс Aconi- tum barba- tum</p>	<p>60-120</p>	<p>Цэцэг нь тод шар өнгөтэй. 5-р сарын хоёр дах 10 хоногоос цухуйж, 7-р сарын сүүлч наймдугаар сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр үр боловсорч, дунджаар 120 хоног ургаад хагдарна. Үрээр үржинэ.</p>	<p>Хусан төгөл, сийрэг шинэсэн ой, тэдгээрийн чөлөө ойн нуга, хээржүү болон нугархаг хажуу байц, асганд ургана. Хур тунадас багатай жилд ногоон бөөсөнд нэрвэгдэнэ. Хүйтэнд тэсвэртэй ургамал.</p>
 <p>Зураг 186. (Жишээ зураг)</p>	<p>Сэгсгэр яргуйжин Anemone crinita</p>	<p>10-60</p>	<p>Цэцэг нь цагаан. Суулгацаар намар тарихад дараа жилийн 5-р сарын гурав дах 10 хоногоос цухуйж, 6-р сарын сүүлчээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын эхээр үр нь боловсорч, дунджаар 100 хоног ургаад хагдарна.</p>	<p>Шинэсэн ой, ойн нуга, ойн зах, нугархаг хажуу, асга, торлог, горхины эрэг, голын ширэнгэ, тагийн нугад элбэг тохиолддог.</p>
 <p>Зураг 187. (Жишээ зураг)</p>	<p>Шар яргуй Pulsatilla fla- vovescens</p>	<p>17-45</p>	<p>5-р сарын эхний 10 хоногт цухуйж 5-р сарын 2-р 10 хоногоос цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын 3-р 10 хоногоос үрлэнэ. Дунджаар 90 хоног ургалт үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, хусан төгөл, тэдгээрийн чөлөө, голын эрэг, бушилзат нуга, сөөгөн ширэнгэ, нугархаг болон хээржүү хажууд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй.</p>
 <p>Зураг 188. (Жишээ зураг)</p>	<p>Турчаниновын яргуй Pulsatilla nuttalla- niana</p>	<p>5-35</p>	<p>Цэцэг нь хөх ягаан, хонхорхуу хэлбэртэй. 5-р сарын 2-р 10 хоногоос цухуйж 5- сарын 3-р 10 хоногоос цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын сүүлээр үрлэж, дунджаар 70 хоног ургаад хагдарна. Үрээр үржинэ.</p>	<p>Элсэрхэг, чулуурхаг хээржүү хажуу, эргийн хайрга, туж, хуурайвтар ойн цоорхойд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p><i>Зураг 189. (Жишээ зураг)</i></p>	<p>Сибирь чөдөр өвс Atragene sibirica</p>	<p>100-140</p>	<p>Цагаан юмуу ягаавтар өнгөтэй өнгийн цэцэгтэй. 5-р сарын эхээр цухуйж 7-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр боловсорч дунджаар 120 хоног ургаад хагдарна. Үр, үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ба холимог ой, тэдгээрийн чөлөө, хусан төгөл, уулсын хажуу ба гол дагасан сөөгөн ширэнгэ, торлог хад цохионы сүүдэр, нударгаар элбэг ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p><i>Зураг 190. (Жишээ зураг)</i></p>	<p>Япон холтсон цэцэг Rapunculus ja- ronica</p>	<p>85</p>	<p>Цэцэг нь шар өнгийн 2см голчтой. 5-р сарын 2-р 10 хоногоос цухуйж 7-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын эхээр үр нь боловсорч, дунджаар 110 хоног ургаад хагдардаг. Үрээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, хусан төгөл, ойн цоорхой, голын эрэг, сөөгөн ширэнгэд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй.</p>
 <p><i>Зураг 191. (Жишээ зураг)</i></p>	<p>Дэлбээрхүү буржгар Thalic- trum pet- aloideum</p>	<p>65</p>	<p>5-р сарын дундуур цухуйж 6-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын эхээр үр боловсорч, дунджаар 110 хоног ургалт үргэлжилнэ. Ургал эрхтнээр үржинэ.</p>	<p>Сийрэг шинэсэн ой, хусан төгөл, ойн цоорхой, өндөр уулын нуга, сөөгөн ширэнгэд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p><i>Зураг 192. (Жишээ зураг)</i></p>	<p>Нүцгэн намуу Ра- raveг pudi- caule</p>	<p>30-40</p>	<p>Цэцэг нь шар өнгийн 6см голчтой. 6-р сарын эхнээс 7-р сарын дундуур цэцэглэж</p>	<p>8-р сарын сүүлээр боловсорч, дунджаар 90 хоног ургаад хагдарна. Шилжүүлэн суулгахад амьдрал муутай.</p>	<p>Элсэрхэг эрэг, голын хайрга, нуга, сөөгөн ширэнгэ, хааяа хээр тал, хээржүү хажууд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p><i>Зураг 193. (Жишээ зураг)</i></p>	<p>Их шүүдэргэнэ Cheilonium majus</p>	<p>40-85</p>	<p>Цэцэг нь шар өнгийн 2.0-2.5см голчтой. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>	<p>8-р сарын сүүлээр үр боловсорч дунджаар 110-120 хоног ургалт үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, хусан төгөл, голын эргийн ширэнгэ, хад цохионы бэл, уулын ам хавцалд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p>Зураг 194. (Жишээ зураг)</p>	<p>Үлдэн могойн идээ Sedum aizoon</p>	<p>25-45</p>	<p>5-р сарын сүүлээр цухуйж 6-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүл 9-р сарын эхээр үрлэж, дунджаар ургалт нь 100 хоног үргэлжилнэ. Үр, үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Ой, ойт хээрийн бүслүүрийн нураг чулуу, хад, асга, голын элсэрхэг хайрганд элбэг тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 195. (Жишээ зураг)</p>	<p>Улбалзуур могойн идээ Sedum rupe-um</p>	<p>25-50</p>	<p>Баг цэцэг нь улбар ягаан өнгөтэй. 5-р сарын 2-р 10 хоногоос цухуйж 7-р сард цэцэглэнэ.</p>	<p>9-р сарын эхээр үрлэж, ойролцоогоор 110 хоног үргэлжилнэ. Үр болон үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Ой, таг цармын хад чулуутай нуга, чулуурхаг хажуу, эргийн хайрга, услагддаг нуга, ойн зах, сөөгөн ширэнгэд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 196. (Жишээ зураг)</p>	<p>Нугын шимтэглээ Geranium pratense</p>	<p>40-45</p>	<p>Цэцэг нь 3.5см голчтой, хөх цэнхэр өнгөтэй. 5-р сарын дундаас цухуйж 6-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үр боловсорч ойролцоогоор 110-120 хоног ургалт үргэлжилнэ.</p>	<p>Шинэсэн ой, хусан төгөл, ойн нуга, ойн зах, эргийн нуга, нугархаг хажуу, сөөгөн ширэнгэд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 197. (Жишээ зураг)</p>	<p>Нарийн навчит хөвөнт Chamaenerion angustifolium</p>	<p>50-120</p>	<p>5-р сарын сүүлчээр цухуйж, 8-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлчээр үр нь боловсорч дунджаар 110 хоног ургаад хагдарна. Үрээр, үндэслэг ишээр тархан үржинэ.</p>	<p>Голын эрэг, хус, шинэсэн ой, түүний цоорхой, ойн захын нуга, нугархаг бэлээр ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэн, ганд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 198. (Жишээ зураг)</p>	<p>Буурал хаварсал Primula farinosa</p>	<p>15-20</p>	<p>Цэцэг нь хүрэн улаан өнгийн, 2.5 см голчтой. 5-р сарын эхний 10 хоногт цухуйж 5-р сарын 3-р 10 хоногт цэцэглэнэ.</p>	<p>6-р сарын сүүлээр үр боловсорч, дунджаар 70 хоног ургаад хагдардаг.</p>	<p>Өндөр уулын таг, ойн бүслүүр дэх чийглэг, намгархаг нуга, гол горхины эрэг, шугуй, ширэнгэ, шинэсэн ой, намгархаг асгад ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p>Зураг 199. (Жишээ зураг)</p>	<p>Хаврын хаварсал Primitula veris</p>	<p>30-50</p>	<p>Цэцэг нь улаан, ягаан, цагаан зэрэг олон өнгөтэй. 5-р сарын эхний 10 хоногт цухуйж, 6-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>Үр нь 7-р сарын сүүлчээс боловсорч, дунджаар 90 хоног ургаад хагдардаг. Үрээр үрждэг.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, намар хучиж өвөлжүүлдэг.</p>
 <p>Зураг 200. (Жишээ зураг)</p>	<p>Буурал Далан товч Androsace incana</p>	<p>3-5</p>	<p>Цэцэг нь цагаан өнгийн 1см голчтой. 5-р сарын эхээр цухуйж 5-р сарын 3-р 10 хоногоос цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын эхээр үр боловсорч, дунджаар 90 хоног ургаад хагдардаг. Үрээр, үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Ойт хээр, хээрийн хайргат ба чулуурхаг хажуу, бэл хавцалд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 201. (Жишээ зураг)</p>	<p>Гоо юлт, Тэмээн хэл Goniolimon sp-ciosum</p>	<p>40-60</p>	<p>Цайвар ягаан өнгийн бамбайрхуу баг цэцэгтэй. 5-р сарын 2-р 10 хоногоос цухуйж 6-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үрлэж, дунджаар ургалт 120 хоног үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Ойт хээр, хээр, цөлийн хайргат хээр, чулуурхаг хажуу, байц хадны ёроолд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэн ганд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 202. (Жишээ зураг)</p>	<p>Говийн ганга Thymus gobicus</p>	<p>3-12</p>	<p>6-р сарын дундуур цухуйж 7-р сарын дунд үед цэцэглэнэ.</p>	<p>9-р сарын эхээр үрлэж ойролцоогоор ургалт нь 90-110 хоног үргэлжилнэ. Үрээр, үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Ойт хээрийн бүсийн уулын чулуурхаг, хайргат хажуу, нураг, байц, говийн бүсийн эргийн хайрга, элсэнд голдуу ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 203. (Жишээ зураг)</p>	<p>Урт навчит гандбадраа Veronica longifolia</p>	<p>70-80</p>	<p>5-р сарын дундуур цухуйж 7-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлчээр үр боловсорч, нийтдээ 110 хоног ургаад хагдарна. Үрээр үржинэ.</p>	<p>Төгөл, шинэсэн ой, түүний цоорхой, ойн болон эргийн нуга, голын эрэг, голын эргийн улиас, бургасны шугуйд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p>Зураг 204. (Жишээ зураг)</p>	<p>Буурал Гандбадраа <i>Veronica incana</i></p>	<p>20-50</p>	<p>Цэцэг нь хөх саарал өнгөтэй. 5 сарын 20-оос цухуйж, 7 дугаар сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>9 сарын эхээр үр боловсорч, дунджаар 100 хоног ургаад хагдарна. Үрээр үржинэ.</p>	<p>Уулын хээржсэн хажуу, хээрийн нуга, шинэсэн төгөл, нарсан ойн захад ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 205. (Жишээ зураг)</p>	<p>Потанины Улаан тулам <i>Incavillea rotaninii</i></p>	<p>10-30</p>	<p>Ягаан цэцэгтэй. Хавар тарихад 7-10 хоногийн дараа соёолно.</p>	<p>Голлосон үндэсний системтэй учраас шилжүүлэн суулгахад амьдрал муутай.</p>	<p>Хайргархаг, чулуурхаг хажуу, хад асга, сайр дагаж ургана.</p>
 <p>Зураг 206. (Жишээ зураг)</p>	<p>Цомцогт бэрцэцэг <i>Scabiosa comosa</i></p>	<p>25-45</p>	<p>Цэцэг нь хөх ягаан өнгөтэй. 5-р сарын 2-р 10 хоногт цухуйж 7-р сарын сүүлээр цэцэглэнэ.</p>	<p>Үр нь 9-р сарын эхээр боловсорч дунджаар 105 хоног ургадаг. Үрээр үржинэ. ургаад хагдардаг.</p>	<p>Хээрийн бүсийн алаг өвст нуга, хээрт, ойт хээрийн бүсийн чулуурхаг, хайргархаг хажуу, сөөгөн ширэнгэд элбэг ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 207. (Жишээ зураг)</p>	<p>Нарийн цэцэгт хонхлой <i>Adenophora stenantha</i></p>	<p>35-37</p>	<p>6-р сарын эхээр цухуйж 7-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>9-р сарын эхээр үрлэж ойролцоогоор ургалт 110 хоног үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Хээрийн ба уулын нугат хажуу, голын эрэг, эргийн нуга, ойн зах, сөөгөн ширэнгэд ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 208. (Жишээ зураг)</p>	<p>Алтайн согсоолж <i>Heterorhappus altaicus</i></p>	<p>30-60</p>	<p>Цэцэг нь цайвар цэнхэр юм уу ягаавтар цэнхэр өнгөтэй. 5-р сарын дундуур цухуйж 6-р сарын 3-р 10 хоногоос цэцэглэнэ.</p>	<p>7-р сарын сүүлээр үрлэж ойролцоогоор ургалт 110 хоног үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Хээр, хээрийн нуга, чулуурхаг, хайргархаг хажуу, хад чулуу, сайрын ёроол, ирмэг, бэл, голын хайрга, сул элсэнд элбэг ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>

 <p>Зураг 209. (Жишээ зураг)</p>	<p>Тагийн гол гэсэр Aster alpinus</p>	<p>3-20</p>	<p>Цэцэг нь сагс, ганцаар 3-5см голчтой, хөх ягаавтар өнгөтэй байдаг. 5-р сарын сүүлээр цухуйж 7-р сарын эхээр цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын сүүлээр үрлэж ойролцоогоор ургалт 110 хоног үргэлжилнэ. Үрээр үржинэ.</p>	<p>Ойт хээр, шинэсэн ой, түүний зах хээржүү чулуурхаг хажуу, тагийн хад чулуу, асга нурангад ургана. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 210. (Жишээ зураг)</p>	<p>Эгэл цагаан түрүү Leontopodium leontopodioides</p>	<p>30-40</p>	<p>Цомцог урт, цагаан халтар. 3-р 10 хоногоос цухуйж 7-р сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>5-р сарын 8-р сарын сүүлээр үрлэж дунджаар 110 хоног үргэлжилнэ. Үрээр, үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Хээржүү хажуу, хуурай хээрт тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 211. (Жишээ зураг)</p>	<p>Азийн төлөгч өвс Achillea asiatica</p>	<p>55-60</p>	<p>Цэцэг нь цайвар ягаан өнгөтэй. 5-р сарын эхний 10 хоногт цухуйж, 6-р сарын дундаас 8-р сарын дунд үе хүртэл цэцэглэнэ.</p>	<p>8-р сарын 3-р 10 хоногоос үр нь боловсорч, 110 хоног ургаад хагдарна. Үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, түүний зах, ойн ба эргийн нуга, сөөгөн ширэнгэд ургана. Гандуу жил хортонд / хар ялаа, ногоон бөөс/ хялбар нэрвэгдэнэ. Хүйтэнд тэсвэртэй ургамал.</p>
 <p>Зураг 212. (Жишээ зураг)</p>	<p>Завадскийн Тунхуу Chrysanthemum zawadskii</p>	<p>15-50</p>	<p>Цэцэг нь 5.5 см голчтой, сагс хэлбэрийн баг цэцэгтэй, цагаан өнгөтэй. 5 сарын эхний 10 хоногт цухуйж, 7 сарын дундуур цэцэглэнэ.</p>	<p>9 сарын эхээр үр боловсорч, дунджаар 120 хоног ургаад хагдардаг. Үр үндэслэг ишээр үржинэ.</p>	<p>Шинэсэн ой, нарсан шугуй, ойн цоорхой, ойн зах, чулуурхаг хажуу, ойн ба эргийн нугад элбэг тохиолдоно. Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэртэй.</p>
 <p>Зураг 213. (Жишээ зураг)</p>	<p>Цуулбар навчит Rudbeckia laciniata</p>	<p>60-80</p>	<p>Хэлэрхүү цэцэг нь шар захтай, хүрэн өнгөтэй, хоолойрхуу цэцэг нь хар хүрэн өнгөтэй. 5 сарын гуравдугаар 10 хоногоос цухуйж, 6 сарын сүүлчээс, 8 сарын сүүлч хүртэл цэцэглэнэ.</p>	<p>9 сарын эхээр үр нь боловсорч, дунджаар 100 орчим хоног ургаад хагдарна.</p>	<p>Өвчин хортонд нэрвэгддэггүй, хүйтэнд тэсвэр муутай учраас намар хучиж дулаална.</p>

6.3. Цэцэгт байгууламжийн ангилал

Цэцэгт байгууламжийг тэгш, тэгш бус хэмтэйгээр цэцгийн мандал, холимог эмжээр, хөвөө, эмжээр, хээ угалз, чулуу мод, ургамлын хослол гэж ангилах бөгөөд мандлын онцлог хэмжээ болон тарьсан ургамал, ургамлын өнгө зэргээр хоорондоо ялгардаг. Үүнд:

- 6.3.1. цэцгийн мандал: дугуй шулуун өнцөгтэй, зууван дөрвөлжин, олон өнцөгт хэлбэртэй байна;
- 6.3.2. холимог эмжээр: нэг, хоёр, олон наст ургамлыг хольж тарьж толбо үүсгэх зориулалттай;
- 6.3.3. хөвөө: явган замын хажуугаар шулуун 1-2 эгнээгээр тарьсан цэцэгт байгууламж байна. хэмжээ нь зам талбайн хэмжээнээс шалтгаалдаг;
- 6.3.4. эмжээр: цэцгийн мандал, хөвөө эсхүл зүлгэн дээр ургамлаа бүлэглэн тарихад түүнийг тойруулан эмжээрлэснийг хэлнэ. өөрөөр хэлбэл ургамал хоорондын заагийг хэлнэ;
- 6.3.5. хээ угалз: ороож угалзруулсан хэлбэртэй цэцгийн мандал ба зүлгэн дээр гоёмсог чимэглэл хийх хэлбэрийг хэлнэ;
- 6.3.6. чулуу, мод ургамлын хослол: энэ нь чулуу, мод, ургамал хосолсон цогцолбор цэцэгт байгууламжийг хэлнэ. сонгож авсан ургамал нь тархаж ургадаггүй, өндөр биш, цомхон ургадаг ургамал байх ёстой;
- 6.3.7. бүлгээр тарих: зүлэгжүүлсэн талбай болон мод, сөөгийн хооронд цэцэгт ургамлыг их хэмжээгээр, том талбайд суулгасан хэлбэр юм;
- 6.3.8. ганц нэгээр суулгах: зүлгэн дээр толбо үүсгэх буюу сөөг ургамалтай хослуулан нэг зүйлийн ургамлыг бусдаас онцгойлон тарьж суулгахыг хэлнэ;
- 6.3.9. цэцгэн хана: цэцэрлэгт хүрээлэнгийн орох хаалга, амрах хэсгийн сүүдрэвч болон урт хонгилыг өндөр ургадаг цэцэг болон асаж авирч, ороож ургадаг ургамлаар чимэглэхийг ойлгоно.

Хүснэгт 14. Цэцэгт байгууламжид ургамал сонгох

Ургамлын нэр		Өндөр, см	1М2 таригдах тоо	Ашиглах хэлбэр
Латин	Монгол			
<i>Ageratum mexicanum</i>	Гүндсамбуу	15-60	40	Эмжээр, хөвөө
<i>Anthriscum majus</i>	Арслангийн жавьж	30-70	20-30	Толбо үүсгэх, эмжээр
<i>Adonis aleppica</i>	Хундага	40-60	-	Хөвөө
<i>Adonis aestivalis</i>	Зуны хундага	25-30	-	Эмжээр, хөвөө
<i>Adonis annua</i>	Намрын хундага	25-30	-	Эмжээр, хөвөө
<i>Alyssum maritimum</i>	Далайн дэмэг	15	10-15	Эмжээр, хөвөө
<i>Alyssum repens</i>	Мөлхөө дэмэг	-	30	Эмжээр, хөвөө
<i>Aster</i>	Голгэсэр	10-20	50	Эмжээр, хөвөө, мандал
<i>Impatiens balsamina</i>	Хумсан будаг цэцэг	50-70	40	Мандал, хөвөө

<i>Tagetes signata</i>	Нарийн навчит хилэнцэцэг	15-20	15-20	Эмжээр, хөвөө, мандал
<i>Tagetes erecta</i>	Өндөр хилэнцэцэг	25-100	30-40	Мандал, хөвөө
<i>Tagetes patula</i>	Далиу хилэнцэцэг	20-40	25-30	Эмжээр, хөвөө, мандал
<i>Verbena hybrida</i>	Ташуур өвс	20-40	45	Мандал, хөвөө
<i>Gaillardia</i>	Гайллард	40-50	40	Бүлэг, хөвөө
<i>Dianthus chinensis</i>	Нангиад башир	35-40	20	Мандал
<i>Dianthus barbatus</i>	Башир	30-50	25	Мандал
<i>Dianthus caryophyllus</i>	Шабо башир	30-45	-	Сууцны тагт чимэглэх
<i>Dimorphoteca annus</i>	Алталж	30-40	20-30	Мандал, хөвөө
<i>Dimorphoteca aurantiaca</i>	Алталж	50	20-25	Мандал, хөвөө
<i>Delphinium ajacis</i>	Гээгцэцэг	50-100	12	Мандал, эмжээ, бүлэг
<i>Convolvulus tricolor</i>	Алаг сэдэргэнэ	30-50	30	Мандал, хөвөө
<i>Phlox drummondii</i>	Аранзалаа	15-75	20-30	Мандал, хөвөө
<i>Iberis</i>		30-40	40	Мандал, эмжээр
<i>Dahlia pinnata</i>	Мандарваа	100-200	5-6	Бүлэг, цэцгэн хана
<i>Callistephus chinensis</i>	Нангиад голгэсэр	20-90	15-45	Мандал, хөвөө
<i>Gypsophila elegans</i>	Тайр	45	50	Эмжээр
<i>Calendula</i>	Хумсанцэцэг	30-60	40	Мандал, хөвөө
<i>Antirrhinum majus</i>	Арслангийн жавьж	20-60	50	Мандал, хөвөө
<i>Tropaelum majus</i>	Гялбалзал	25-30	20-25	Мандал, хөвөө
<i>Petunia hybrida</i>	Хунцэцэг	20-40	25-40	Мандал, хөвөө
<i>Portulaca l</i>	Мориншүд	15-20	50-60	Мандал, эмжээр
<i>Reseda odorata</i>	Анхилуун танар	20-40	40	Эмжээр
<i>Scabiosa atropurpurea</i>	Бааварцэцэг	90	35-40	Мандал, эмжээр, бүлэг
<i>Amaranthus caudatus</i>	Гагадай	100	40-60	Толбо
<i>Godetia amoena</i>	Цайгана	30-50	30	Эмжээр
<i>Lobelia erinus</i>	Ловил	10-15		Эмжээр, толбо
<i>Dendranthema</i>	Удвалгана	50-60	45	Хөвөө, бүлэг
<i>Zinnia</i>	Хүмээс	40-90	20-35	Мандал, хөвөө
<i>Eschscholzia</i>	Намуулиг	30-40	45-50	Мандал, хөвөө
<i>Campanula l.</i>	Хонхонцэцэг	45-90	25	Бүлэг, цэцгэн хана
<i>Eritrichium schrad.</i>	Бадха	20-30	70	Мандал, хөвөө







Pheum l.	Гишүүнэ	150-200	1-2	Ганц нэгээр, бүлэг
Helichrysum plicatum	Хуурайцэцэгтэн	25-100	-	Хөвөө, бүлэг
Delphinium hybridum	Гээгэнэ	80-120	10-12	Хөвөө, бүлэг
Paeonia l.	Цээнэ	50-100	1-2	Мандал, эмжээр, бүлэг
Pheum l.	Гишүүнэ	150-200	2-4	Бүлэг, ганц нэгээр
Begonia tuberosa l.	Булцуут хайтан	20-50	25	Эмжээр, хөвөө
Lilium l.	Сарна	50-120	5-10	Бүлэг, цэцгэн хана
Tulipa l.	Зулцэцэг	30-50	40-50	Бүлэг
Viola tricolor	Нил	15-30	15-20	Эмжээр, хөвөө

6.4 Цэцгийн ургамлыг тарьж ургуулах

Төрөл бүрийн чимэглэлийн цэцэгт ургамлыг үрээр шууд тарих, үрсэлгээгээр тарих гэсэн үндсэн 2 арга байдаг. Ихэнх ганц настай цэцэг нь үрсэлгээгээр дамжиж ургадаг бөгөөд эдгээр нь ургалтын хугацаа урттай, жижиг үртэй учраас аль болох эрт үрсэлгээг хийдэг.

- 6.4.1. Ургалтын хугацаа урттай жижиг үртэй чимэглэлийн ганц наст цэцгийг 2-р сарын сүүлчээс 3-р сарын нэгдүгээр 10 хоногт үрсэлгээг хийнэ. Ганц наст цэцгийн үрсэлгээ хийх хугацааг Ганц наст цэцэг тарих арга MNS 6259: 2011 стандартыг мөрдөнө.
- 6.4.2. Үр тарихад хар шороо, элсийг 6:4 харьцаатай хольж хэрэглэнэ. Бэлтгэсэн хөрсийг сайтар тэгшлээд, нэвчтэл усална.
- 6.4.3. Хот тохижилтод үрсэлгээг тээвэрлэхдээ ургаж буй хайрцагтай нь цэцгийн дэлбээг гэмтээхээргүй нөхцөлд тээвэрлэнэ.
- 6.4.4. Сайн чанарын шилбэ бүдүүнтэй үрсэлгээг ил талбай, мандалд суулгахдаа цочир хүйтрэлт өнгөрсний дараа тарина. Үрслэгээг суулгасны дараа услах ба үзлэг хийж, 3-5 хоногт багтаан нөхөн тарилтыг хийнэ.
- 6.4.5. Цэцгийг ургалтын хугацааны арчилгааг Ганц наст цэцэг тарих MNS 6259: 2011, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн арчлалт, усалгааны менежмент UCS 0804A: 2020 баримт бичгийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

Хүснэгт 15. Цэцгийн ургамлыг тарих

 <p data-bbox="327 537 651 570"><i>Зураг 214. (Жишээ зураг)</i></p>	 <p data-bbox="957 537 1281 570"><i>Зураг 215. (Жишээ зураг)</i></p>
<p data-bbox="183 598 774 722">Хөрсийг 20-22 см гүн хагалж чулуу, хог ургамлын үндсийг цэвэрлээд, багсармал бордоог хольж усалж чийглэн тэгшилж тарих дэвсгийг бэлдэнэ.</p>	<p data-bbox="821 609 1412 707">Үрийг тарихдаа үрийн том, жижгээс шалтгаалан 1.0-1.5 см гүн хүртэл шороогоор хучиж, сайн нягтруулаад усална.</p>
 <p data-bbox="327 1046 651 1078"><i>Зураг 216. (Жишээ зураг)</i></p>	 <p data-bbox="957 1046 1281 1078"><i>Зураг 217. (Жишээ зураг)</i></p>
<p data-bbox="183 1122 774 1247">Ил талбай болон мандалд суулгах үрсэлгээг нэг өдрийн өмнө усална. Үрслэгийг ил талбайд суулгахдаа сайн чанарын шилбэ бүдүүнтэй үрслэгийг сонгон авч суулгана.</p>	<p data-bbox="821 1109 1412 1262">Хайрцагнаас үрсэлгээг авахдаа үндэс гэмтээхээс хамгаалж, шорооны хамт зүсэж авна. Мөн бэлтгэсэн талбайгаа тэгшлээд элдэв дүрс гаргахын тулд олс эсхүл утас татаж гадаслана.</p>
 <p data-bbox="327 1603 651 1635"><i>Зураг 218. (Жишээ зураг)</i></p>	 <p data-bbox="957 1603 1281 1635"><i>Зураг 219. (Жишээ зураг)</i></p>
<p data-bbox="183 1690 774 1749">Үрслэг суулгасны дараа усалгааг өдөрт 2 удаа, цаашид өдөрт 1 удаа өглөө оройн цагаар хийнэ.</p>	<p data-bbox="821 1677 1412 1764">Цэцгийн мандлыг арчилгааг MNS 6259:2011, UCS0804A:2020 баримт бичгийн технологийн дагуу гүйцэтгэнэ.</p>

7. НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ШАЛГАХ ХУУДАС

7.1. Мод, сөөгийн суулгацын хяналт, үнэлгээ хийх чиглэл

Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажилд мод, сөөгийн суулгац нь хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлт (хүснэгт 7.1) -ийг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 16. Мод, сөөгийн суулгацын хяналт, үнэлгээ хийх чиглэл

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Суулгацын шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Тарих суулгацын нүхний хэмжээг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Суулгах нүхийг ухахдаа үржил шимт хөрсийг ялгаж бэлтгэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Шинээр хөрсжүүлэх хар шороо, элс, холимог бордооны шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Суулгацыг технологийн дагуу тарьсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Тарьсны дараа суулгацыг ханатал усалсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Ургалтын хугацааны усалгааны шаардлагыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Ургалтын хугацааны арчилгааны шаардлагыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Мод, сөөгийн суулгацын хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд 75%-аас дээш нөхцөлийг хангасан тохиолдолд “Тийм”, 60-75% хүртэлх нөхцөлд “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

7.2. Зүлэгжүүлэх талбайн хяналт, үнэлгээ хийх чиглэл

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажилд зүлэгжүүлэх талбайн хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтийг (хүснэгт 7.2) -ийг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 17. Зүлэгжүүлэх талбайн хяналт, үнэлгээ хийх чиглэл

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Зүлгийн үр нь чанарын шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Хөрс боловсруулалтын шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Өнгөн хөрс бэлтгэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Үр тарихын өмнөх усалгааг хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Үрийг нормын дагуу тарьсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Үрийг тарьсны дараах усалгааг ханатал хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Ургалтын хугацааны арчилгааны шаардлагыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Зүлэгжүүлэх талбайн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд 75%-аас дээш нөхцөлийг хангасан тохиолдолд “Тийм”, 60-75% хүртэлх нөхцөлд “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

7.3. ЦЭЦГИЙН ҮР, ҮРСЭЛГЭЭД ТАВИХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЧИГЛЭЛ

Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн ажилд цэцгийн үр, үрсэлгээд тавих хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлтийг (хүснэгт 8.3) -ийг хангаж буйг хянаж шалгана.

Хүснэгт 18. Цэцгийн үр, үрсэлгээд тавих хяналт, үнэлгээ хийх чиглэл

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Үр болон үрслэгээний шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Үр, үрслэгээ тарихад шаардлагатай хөрс боловсруулалтыг хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Үрсэлгээ зөв тээвэрлэлтийн шаардлага хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Үр, үрсэлгээг цэцгийн мандалд нормын дагуу шилжүүлэн суулгасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Үр, үрсэлгээг тарьсны дараа усалгааг хийсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Ургалтын хугацааны усалгааны шаардлагыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Ургалтын хугацааны арчилгааны шаардлагыг хангасан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Цэцгийн үр, үрсэлгээд тавих хяналт, үнэлгээний шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд 75%-аас дээш нөхцөлийг хангасан тохиолдолд “Тийм”, 60-75% хүртэлх нөхцөлд “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Ариунсүрэн П., Түмэнжаргал Д. Монголын нөхцөлд зүлэг ширэг үйлдвэрлэх боломж. Улаанбаатар, 2009: -55 х.
- Бат-Эрдэнэ. Ж, Ойн аж ахуйн үндсэн ажлууд. УБ 2011
- БОНХАЖЯ. Мод тарих гарын авлага.УБ 2015
- Бэлчээр ашиглалтын нөлөөг фото зургаар баримтжуулах замаар хянах нь. - Улаанбаатар: 2014. – Х. 22.
- Бат-Эрдэнэ. Ж., Мөнхбат Г. “Ойн зурвас байгуулах технологи” гарын авлага 2018, х.48
- Байгаль орчны яам, Монголын байгаль орчны консорциум, Нидерландын засгийн газар, Дэлхийн банк “Цэцэг, зүлэг тарих, мод суулгах, бут сөөг ургуулах зөвлөмж”
- Бондарева О.Б. Клумбы и живые изгороди. Сталкер: 2007
- ГОСТ 24909: 81 Чимэглэлийн навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 25769-83 Хотын ногоон байгууламжид зориулсан шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага.
- ГОСТ 28829-90 Хамгаалагдсан хөрстэй мод сөөгийн суулгац. Техникийн шаардлага
- ГОСТ 24835-81, Мод, сөөгийн суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 24909-81, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 25769-83, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- ГОСТ 26869-86, Сөөгийн суулгац. Техникийн шаардлага.
- Гангаамаа. Х, “байгалийн олон наст өвслөг ургамлын ландшафт дизайнд гүйцэтгэх үүрэг”, Ландшафтын архитектур 15 жил, эрдэм шинжилгээний бага хурал, УБ, 2014, х.8-20.
- Gen Xin etc. Application Design of Garden Plants. China Beejing: 2007
- Жавзан С., Очгэрэл Н. Цэцэгт байгууламж тэдгээрт тарих ганц наст цэцэгс. УБ: 2010
- Хот суурин газрын ногоон байгууламжийн бүтэц, экологийг сайжруулах асуудал. - Улаанбаатар, 2013: -187Х.
- Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он
- MNS 6263: 2011, Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээж авах.
- MNS 6139 : 2010, Шилмүүст төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- MNS 6141 : 2010, Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага,
- Ойн нэвтэрхий толь. УБ, 2017
- Одонгэрэл С, Ариунбаяр Э., “Чимэглэлийн модлог ургамал”. УБ 2016.
- Өлзийхутаг Н. БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг, УХГ. УБ.-1985
- Чанцалням.Д Ботаникийн цэцэрлэгийн нөхцөлд тарималжуулсан мод, сөөг ургамал. УБ 2010

- Энхсайхан Д. Монгол орны мод, сөөг, Улаанбаатар хот, 2014, х.232
- Эрдэнэжав Г., Чанцалням Д., Цэрэннадмид П., Жавзан С., Мядаг С., Энхтуяа Л., Мөнгөн М. Ургамлын интродукцийн үр дүн ба амжилт. Улаанбаатар, 2001: -274.х.
- <http://www.legalinfo.mn>
- <https://environment.ub.gov.mn>
- <https://www.mascus.ru/>

ТЭМДЭГЛЭЛ

Blank page with horizontal dotted lines for writing.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар